

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨНИЙ ТАЙЛАН**

Д/Д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдэх	1.1. АТГ-аас Соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг - Байгууллагын албан ёсны цахим хуудас, - Сошиал сувгууд - Дотоод сүлжээ - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл - Мэдээлэл, сурталчилгааны самбар, Лед дэлгэц - Бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж олон нийтэд хүргэх;	Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд нь тайлагнадаг байх; Харъяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; Тайланд холбогдох нотломжийг хавсаргах.	Төвийн цахим хуудсанд / www.hdc.gov.mn/ “Авлигын эсрэг” цэс үүсгэсэн бөгөөд уг цэсийг АТГ-аас ирүүлсэн болон бэлтгэн түгээсэн контентуудаар шинэчилж байна. Түүнчлэн Мэдээллийн дэлгэц, дотоод сүлжээгээр дамжуулан мэдээлэл, сурталчилгааны ажил явуулж соён гэрээгүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд: - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр - ЭМХТ-ийн 2025 оны Авлигийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө - ХАСХОМ бүрдүүлэлтийн цахим системд орсон өөрчлөлт - ХАСХОМ нэвтрэн орох заавар - ХАСХОМ баталгаажуулах заавар - Авлигыг таслан зогсооход хүн бүрийн хүчин чармайлт чухал зэрэг мэдээллүүдийг түгээгээд байна. - Авлигын талаарх ойлголт - Сургалтын видео хичээлүүд

				- Авлигын эсрэг хууль тогтоомжууд - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/ - Авлигын эсрэг контентууд
		1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах;	Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; АТГ-аас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; Үр дүнг тооцсон байх.	- Жил бүр зохион байгуулагддаг “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын элсэлт, төгсөлт”, “Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их дээд сургууль, коллеж төгссөн төгсөгчдөөс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын шалгалтын комиссын бүрэлдэхүүн”-д томилогдсон ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүд болон бусад бүрэлдэхүүнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргах” тухай 2 удаагийн сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, албан тушаалтанд тавигдах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт, нийтлэг ирдэг өргөдөл, гомдол, албан тушаалтнуудын гаргадаг зөрчил дутагдал, анхаарах асуудлын чиглэлээр мэдээлэл өгсөн. - Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах Үндсэн мэргэшлийн сургалтад элсэхээр бүртгүүлсэн шалгуулагчдад 2025 оны 09 сарын 12-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөгөө өглөө. Уг сургалтаар АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалт, хориглолт, хязгаарлалтаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, өргөдөл гомдлоо хэрхэн хаана гаргах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Нийт 568 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - Төгсөлтийн дараах сургалтын элсэлт, Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалттай холбогдуулан Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4

				төрлийн Рийл бэлтгэн төвийн цахим болон нүүр хуудсаар олон нийтэд хүргэсэн.
		1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах;	- Мэдээллийг АТГ-аас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд олон нийт уруу чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргах.	Төвийн цахим болон нүүр хуудсанд 110 дугаарыг сурталчилсан 3 контент бэлтгэн байршууллаа. Үүнд: - Шударга ёс, хөгжил дэвшилд 110 гомдол мэдээлэл - 110 Авлигын мэдээлэл - Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтын гомдол мэдээллээ 110 утсаар ирүүлнэ үү 
		1.4. Өөрсөдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёсзүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх;	- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд хүргэн сурталчилсан байх.	Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтын үеэр Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 2 төрлийн видео контент бэлтгэн төвийн цахим хуудас, мэдээллийн дэлгэцээр олон нийтэд хүргэн сурталчиллаа. https://www.facebook.com/reel/813917817793877 https://www.facebook.com/reel/783575944479367

2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлыг бууруулах олон нийтийн хяналтыг сайжруулах	2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын журам”-ыг хэрэгжүүлэх;	- Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; - Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.	1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган https://www.infoshilendans.gov.mn сайтад дараах мэдээллийг байршуулсан. Үүнд: • 2025 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт; • Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл; • 2025 оны төсөвт орсон нэмэлт өөрчлөлт; • 2025 оны төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт; • Байгууллагын батлагдсан тоонд орсон өөрчлөлт зэрэг сар бүр тавих мэдээллүүд; • 2025 оны ХАА-ны төлөвлөгөө; • Байгууллагын батлагдсан төсөв; • Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг ажил тавих мэдээллүүд; • Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл; • Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ; • Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл; • Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр; • Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ; • Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг тухай бүр тавих мэдээллүүд зэрэг орсон. Шилэн дансанд 2025 оны байдлаар нийт 29 төрлийн 139 мэдээ мэдээллийг
---	--	--	--	--

			байршуулж олон нийтийн хяналт хийх боломжийг ханган ажилласан.
			- Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөх арга хэмжээний хүрээнд 2025 оны 12 сарын байдлаар ЭМХТ-д ажиллаж буй 75 албан хаагчид давхар ажил эрхлээгүй бөгөөд хандив, төлбөр тусламж авалгүй хориглолт, хязгаарлалтын зөрчилгүй ажиллаж байна. - Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц, нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх чиглэлээр: Мөн төвийн хэмжээнд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, зөрчил үүссэн эсэх тухай давхардсан тоогоор 30 мэдэгдэл, тайлбар гаргасан. Эдгээр мэдэгдэл, тайлбарт ямар нэг зөрчил үүсээгүй ба хориглолт, хязгаарлалтыг аливаа хэлбэрээр зөрчөөгүй ажилласан. - Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программ хангамжийн үйл ажиллагааны чанар хүртээмж болон хэрэгцээт нэмэлт өөрчлөлт оруулах талаар QR код үүсгэн санал асуулга явуулж.
	2.3. Төсвийн орлогоор санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;	- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар иргэд олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар мэдээлэх; - Иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах.	- Үндэсний аудитын газраас 2024 оны санхүүгийн тайланд түүвэр аудит хийгдсэн ба аудитлагдсан санхүүгийн тайлан дүгнэлт, зөвлөмж тусгайлан гараагүй харин зөрчил арилгах тухай албан шаардлага ирүүлсэн ба шаардлагын биелэлтийн тайланг 2025.04.25-нд уг тайланг www.infoshilendans.gov.mn байршуулсан. - https://shilendans.gov.mn/organization/12757?ry=2024&group=117 ШИЛЭН ДАНС-ны мэдээ, мэдээллийг хуулинд заасан өгөгдлийн дагуу, хуулийн хугацаанд байршуулсан. Үүнд: Шилэн дансанд 2025 оны 11 сарын байдлаар нийт 29 төрлийн 139 мэдээ мэдээлэл тавигдсан. 12 сарын мэдээллүүдээ хуулийн хугацаанд (дараа сарын 07-ны дотор) тавих болно

				- Тендерийг Tender.gov.mn цахим хуудсаар зарлан, нээлттэй ил тод шалгаруулалт явуулдаг. Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулав. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийхээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-д ЭМХТ-ийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендер зарласан. Уг тендерт 1 байгууллага оролцсон ба дээрх ДУНДИ ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичиг боловсруулан гаргаж үр дүнг цахим системд нийтлэв. Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх гэрээг ДУНДИ ХХК-тай байгуулсан.
		2.4. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;	- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой гомдол мэдээллийн судалгааг тогтмол гаргаж тайлагнах; - Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хуулийн хүрээнд шуурхай бодитой, шийдвэрлэх.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал бүрээр нь гарган цахим хуудасны “Ил тод” хэсэгт байршуулдаг. Сүүлийн 3 жилээр үзэж болохоос гадна өргөдөл, гомдол гаргах хэлбэр, өргөдөл бичих загвар, Иргэдийг хүлээн авах хуваарь зэргийг хамт байршуулж өгсөн болно. https://hdc.gov.mn/page/63/ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт хийн 7 хоног бүр байгууллагын дотоод сүлжээ, Удирдлагын шуурхай хурлаар мэдээлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцлийг	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас иргэд олон нийтэд цахимаар үзүүлж буй	- Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд олон	Манай байгууллагаас эрүүл мэндийн салбарын цахимжилт, нэгдсэн сан, мэдээлэл солилцооны системийн хөгжүүлэлт, хэвийн, найдвартай үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиг үүргийнхээ хүрээнд Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний үйл ажиллагааг цахимжууллаа.

	арилгуулах арга хэмжээ авах.	үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	- нийтээс судалгаа, санал асуулга авах; Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хэрэгжилтийг тайлагнах.	Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын дагуу хийгддэг бөгөөд иргэд Цагаан дэвтэр гэдгээр мэддэг буюу худалдаа, тогооч, цэцэрлэгийн багш, хүнс үйлдвэрлэгч зэрэг үйл ажиллагаа эрхлэхэд авдаг үзлэг, шинжилгээ юм. Нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу манай байгууллагаас ЭМЯ, ЦХИХХЯ, И-Монгол академи, НЭМГ, Эмнэлгийн цахим систем хөгжүүлэгч компани, Чингэлтэй дүүргийн ЭМТ-тэй хамтран богино хугацаанд уг цахимжиуулах үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ /Цагаан дэвтэр/-г цахимжуулснаар: • Үзлэг, шинжилгээний бүртгэл, тайлан, үйл ажиллагааг цахимаар хянах боломж бүрдэнэ. • Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний мэдээллийн чанар сайжирна. • Үзлэг, шинжилгээний хариуг хуурамчаар үйлдэх боломжгүй болно. • Хүний өмнөөс шинжилгээ өгдөг асуудал байхгүй болно. • Зөвшөөрөгдөөгүй эмнэлэгт үзлэг, шинжилгээ хийлгэх боломжгүй болно. • Иргэд шинжилгээний хариуг E-Mongolia системээр авах боломж бүрдлээ.
		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	- Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг АТГ-т шилжүүлэх; - Байгууллагын үйл ажиллагаанд тохируулан албан	2025 онд Төвийн албан хаагчидтай холбогдуулан авлига, ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл ирээгүй болно. ХШҮА-наас нэмэх

			хаагчдын ашиг сонирхолын зөрчилд хүргэх эрсдлийг тодорхойлсон байх; - Эрсдлийг арилгахад чиглэсэн дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх.	
		3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэ санал, санаачилга гарган арга хэмжээг хэрэгжүүлэх;	Төлөвлөгөөний 1.1-3.2 дах хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх. - Байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ	1. Тагсалтийн дараах сургалтын элсэлтийн шалгалтын үеэр хэрэгжүүлсэн Авлига, ашиг, сонирхолын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээ бэлтгэн төвийн цахим хуудсаар байршууллаа. 2. АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу цахим хуудсанд 2 мэдээлэл бэлтгэн байршуулсан Үүнд: • Авлигын эсрэг мэдээллийг 110 утсанд мэдэгдэнэ үү. • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/ Шинээр албан тушаалд томилогдох 8 хүний ХАСУМ хчнуулах албан бичгийг хүргүүлэн АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжлтийг ханган ажиллаа. 3. Жил бүр зохион байгуулагддаг “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын элсэлт, төгсөлт”, “Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их дээд сургууль, коллеж төгссөн төгсөгчдөөс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын шалгалтын комиссын бүрэлдэхүүн”-д томилогдсон ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүд болон бусад бүрэлдэхүүнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргах” тухай 2 удаагийн сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх

				хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, албан тушаалтанд тавигдах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт, нийтлэг ирдэг өргөдөл, гомдол, албан тушаалтнуудын гаргадаг зөрчил дутагдал, анхаарах асуудлын чиглэлээр мэдээлэл өгсөн. 4. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах Үндсэн мэргэшлийн сургалтад элсэхээр бүртгүүлсэн шалгуулагчдад 2025 оны 09 сарын 12-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөгөө өглөө. Уг сургалтаар АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалт, хориглолт, хязгаарлалтаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, өргөдөл гомдлоо хэрхэн хаана гаргах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Нийт 568 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1. 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	- Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; - Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.	2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1-р улиралд Мэдээллийн цагаар албан хаагчдад танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан гарсан бөгөөд 12 сарын сүүлээр зохион байгуулах Тайлангийн хурлаар хэрэгжилтийн хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулахаар бэлтгэж байна.
		4.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	- Санал тусгасан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Санал авах дүрэм журам 2025 онд боловсруулаагүй болно.
		4.3. Эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн бүртгэлийн удирдлага, лабораторийн удирдлага, мэдүүлгийн удирдлага, хэрэглэгчийн эрхийн удирдлага зэрэг үндсэн модулиудын өгөгдлийн архитектурыг оновчтой зохион байгуулах, ажлын урсгалын процессыг тодорхойлон, системийг

				хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, хялбар болгох зорилгоор хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг 1.0 хувилбарыг модулиудын түвшинд холбогдох мэргэжилтнүүд болон ажлын хэсэгт хугацаандаа хүлээлгэн өгсөн. Мөн ЭЭХХЗГ-ын мэргэжилтнүүд болон эм ханган нийлүүлэх байгууллагын төлөөлөлд зориулсан системийн хэрэглээний сургалтыг амжилттай зохион байгуулсан. Гарын авлагыг хэрэглэгчийн түвшин, гүйцэтгэх үүрэг, систем ашиглах эрхийн ангиллын дагуу ялган боловсруулж, нийт 3 үндсэн удирдлагын бүлэг, мөн байгууллагын хэрэглэгчдэд зориулсан нэмэлт гарын авлага бэлтгэн хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 100 хоногийн хүрээнд эмийн үнийн ил тод байдлыг хангах, иргэдийн хяналтыг сайжруулах зорилгын дагуу эм ханган нийлүүлэх байгууллагуудын хаягийн мэдээлэл, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүний мэдээллийг харах боломжтой жагсаалтыг боловсруулж, веб хуудсанд холбосон. - 2 GET болон 1 POST сервисийн хөгжүүлэлт бүрэн хийгдсэн. Энэхүү сервисүүд нь Гаалийн ерөнхий газартай эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, био бэлдмэл болон түүхий эдийн мэдээлэл, мөн экспорт, импортын мэдээллийг харилцан солилцох боломжийг бүрдүүлж ажилладаг. • ServiceLicenseAllCustom: Хоёр огнооны хооронд мэдүүлэг бүрдүүлсэн бүх бүтээгдэхүүний мэдээллийг илгээдэг сервис. • ServiceLicenseCustomProducts: Хоёр огнооны хооронд мэдүүлэг бүрдүүлсэн бүтээгдэхүүний мэдээллийг мэдүүлгийн дугаараар шүүж илгээдэг сервис. • ServiceLicenseCustomProductDetail: Гаалийн ерөнхий газраас хилээр импортлогдсон, экспортлогдсон бүтээгдэхүүний мэдээлэл, тоо хэмжээ, үнийн мэдээлэл зэрэг шаардлагатай өгөгдлүүдийг шинэ систем рүү дамжуулан илгээдэг сервис. Засгийн газрын 100 хоногт эмийн үнийн ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд эмийн борлуулагдаж байгаа эмийн сангуудыг байршил, үнэтэй нь харуулахад холбогдох сервис болон вэб порталыг хөгжүүлж, нэвтрүүлсэн. /em.hdc.gov.mn/ - ЭЭХХЗГ-аас эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг авах, холбох сервис хөгжүүлсэн. ЭМСайд 2025 оны 10 сарын 7-
--	--	--	--	---

				ны өдөр олон нийтэд системийг танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулсан. - https://backend.acc.hdc.gov.mn/ магадлан итгэмжлэлийн цахим системээр 2025 он 11 сарын байдлаар нийт 357 эрүүл мэндийн байгууллагын материалыг хүлээн авч магадлан итгэмжлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулсан. МИЗ-ийн 21 удаагийн хурлаар нийслэлийн 123, орон нутгийн 234 эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжилж, батламжийг цахимаар олгосон байна. - Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаарын 2-р хавсралт, 2024 оны А/112 дугаар тушаалын 1-р хавсралт Эрүүл мэндийн байгууллагын тохиолдол, эрсдэлийг бүртгэх тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагууд http://eburtgel.hdc.gov.mn/ цахим мэдээллийн нэгдсэн санд 2694 тохиолдол, 1613 эрсдэлийг бүртгэгдэж, сайн туршлага 116-г нэвтрүүлсэн байна. https://health.acc.hdc.gov.mn/ тус цахим системд магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол, саналыг хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн. Нийт хүсэлт 357, санал 25, гомдол ирээгүй болно. Мөн тус системд магадлан итгэмжлэл олгосон ЭМС-ын 22 удаагийн хурлын тушаалыг байршуулсан. - “Хүний нөөцийн бүртгэл мэдээллийн сан” программд шалгалтын төлбөр, тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөх модулуудыг үүсгэн цахимаар төлбөр төлөлтүүд хийгдэж байна. 2025 онд дээрх төлбөрийн модуль ашиглан: • Төрөлжсөн мэргэшлийн төгсөлтийн шалгалт 4683 хүн 46,830,000 төгрөг, • Зөвшөөрлийн шалгалт 14565 хүн 174,780,000 төгрөг. • Шалгалтын нийт төлбөр 19248 хүн 221,610,000 төгрөг. • Тэмдэгтийн хураамж 12936 эмнэлийн мэргэжилтэн 64,680,000 төгрөг, • Резидент 127 эмч, 1,270,000 төгрөг, • Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн 209 ажилтан 25,080,000 төгрөг, тэмдэгтийн хураамжийн нийт төлбөр 91,030,000 төгрөг.
--	--	--	--	--

		4.4. Худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор энэ чиглэлийн сургалтад албан хаагчдыг хамруулж, үнэлгээний хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх;	Тайланд нотломжийг хавсаргасан байна.	Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 16 албан хаагч хамрагдан 8 албан хаагч шалгалтандаа тэнцээд байна. Суралцсан албан хаагчдын нэрс: - Г.Сайнсанаа ЦХА - П.Баярцэцэг ТҮЧМИА - Б.Атарцэцэг ЭШСҮАЗА - Б.Үзмээ ЦХА - Л.Баянжаргал ХШҮА - Х.Дэлгэрмаа ИӨСА - Б.Болорчимэг ТҮЧМИА - Б.Базаррагчаа ГЭЗА - Я.Бадамсүрэн ЭШСҮАЗА - Г.Нямдаваа ЦХА - М.Цолмон ЦХА
--	--	---	--	--